



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

“Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд ”-д хийсэн санхүүгийн аудитын тайлан

Төрийн сангийн үйл ажиллагааны журмын хэрэгжилт шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна.

2018 он

Уг тайланг WWW.AUDIT.MN сайтаас үзнэ үү.

Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж

тодруулах , асууж лавлах зүйл байвал 70463783 , 70463612 дугаарын утсаар харилцана уу засварлах?????

ХАЯГ:

Завхан аймаг дахь Төрийн аудитын газар
Улиастай сум, Жинст багийн
Нутгийн захиргааны ордон
309,310 тоот өрөө

Гүйцэтгэсэн:

Ахлах аудитор
Д.Оюунжаргал
Аудитор Б.Мөнхнасан
Г.Чулуунбаатар

Хянасан:

Дарга бөгөөд Тэргүүлэх
аудитор Л.Уламбаяр

Аудитын менежер
Г.Хашцэцэг

2018.10.25

АГУУЛГА

Тайланг бэлтгэсэн: Завхан аймаг дахь Төрийн аудитын газар	Товчилсон үгийн жагсаалт	3
	Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	4
	Аудитын зорилт	4
	Аудитын хамрах хүрээ	4
Дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Л.Уламбаяр	Арга зүй	4
	Аудит хийх бүрэлдэхүүн	4
	Аудитын тайлан.....	
Аудитын менежер Г.Хашцэцэг	Зорилт 1. Төрийн сангийн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан байна уу?	7-8
Ахлах аудитор Д.Оюунжаргал	Зорилт 2. Төрийн сангийн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байна уу?	
Аудитор Б.Мөнхнасан, Г. Чулуунбаатар	Дүгнэлт	9-10
2018 оны 11 дүгээр сар Тайланг ҮАГ-ын веб сайт-аас үзнэ үү. www.audit.mn	Зөвлөмж	6-10
Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70463783, 70463612 дугаарын утсаар харилцана уу.	Холбогдох байгууллагын санал	13-14
Хаяг: Завхан аймаг дахь Төрийн аудитын газар Нутгийн удирдлагын ордон	Дарга бөгөөд тэргүүлэх аудиторын тушаал	15-16
Улиастай сум Жинст баг	Хавсралтууд.....	17-18
		19-20

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ҮАГ	Үндэсний аудитын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗГ	Засгийн газар
УИХ	Улсын Их Хурал
ЗГСУМС	Засгийн газрын сангийн удирдлага мэдээллийн систем
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль

“Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд ”-д хийсэн санхүүгийн
аудитын тайлан

Аудит хийх үндэслэл

Аудитыг Төсвийн Байнгын хорооны 2017 оны “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдэв батлах тухай” 06 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын А/06 дугаар тушаалаар батлагдсан ҮАГ-ын 2018 онд аудит хийх төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааг явуулахдаа өөрийн нөөцийг үр ашигтай ашиглаж дэвшүүлсэн зорилго, зорилтоо хэрхэн биелүүлж хэрэглэгч, үйлчлүүлэгчдийн хэрэгцээ шаардлагыг хэрхэн хангаж байгаад үнэлэлт, дүгнэлт өгч үр дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдлээ.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг хийлээ.
Үүнд:

1. Төрийн сангийн нэгдсэн тогтолцоо оновчтой зохион байгуулагдсан эсэх
2. Төрийн сангийн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх

Хамарсан хүрээ:

Аудитыг Төрийн сангийн 2017 оны үйл ажиллагаатай холбоотой баримт материалд тулгуурлан гүйцэтгэсэн бөгөөд аймгийн төрийн сан, 24 сумын санхүүгийн алба, зарим төсвийн байгууллагуудыг хамрууллаа.

Арга зүй:

Аудитыг Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаалаар батлагдсан гүйцэтгэлийн аудитын журмын дагуу Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагаанд мөрдөж буй хууль, тогтоол, түүнийг дагалдан гаргасан эрх зүйн актуудын хүрээнд хэрэгжүүлэгч байгууллага, нэгжийн холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, санал асуулга, лавлагаа, тодруулга авч аймгийн төрийн сан болон сумдын ЗДТГ-ын санхүүгийн албадуудын мемориалын баримтууд, төсвийн байгууллагуудын анхан шатны баримт, дансны хуулгыг тулган, дүн шинжилгээ хийх, хяналт хэрэгжүүлсэн байгууллагуудын тайлан, судалгаа зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажиллалаа.

Аудит хийх бүрэлдэхүүн:

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор Л.Уламбаяр, аудитын менежер Г.Хашцэцэг нар удирдан арга зүйгээр ханган, явцын хяналт тавьж, ҮАГ-аас ирүүлсэн төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүйн дагуу багийн ахлагч ахлах аудитор Д.Оюунжаргал, аудитор Б.Мөнхнасан, Г.Чулуунбаатар нар хийж гүйцэтгэлээ.

Зорилт А. Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан зааврын хэрэгжилт шаардлагын хэмжээнд хүрэхгүй байна

А.1 Төрийн сангийн үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомжууд бусад эрх зүйн акттай уялдаж байна.

Төсвийн тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2, 36.3, 36.4 дүгээр заалтуудад аймаг нийслэл, сум дүүргийн төрийн сангийн бүтцийг тус тус хуульчилж, Сангийн сайдын 2015 оны 90 тоот тушаалаар Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг зааврыг баталсан байна.

Монгол улсын Засгийн газрын 2002 оны 101-р тогтоолоор аймгийн Засаг даргын тамгын газарт Төрийн сангийн хэлтэс байгуулагдаж төсөвт байгууллагуудыг төрийн сангийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлснээр төсвийн хэрэгжилтийг оновчтой зохион байгуулах, төсвийн байгууллагуудын дансыг төрийн санд байршуулж, төсвийг зориулалтын дагуу зарцуулахад хяналт тавих бололцоотой болжээ.

Аймгийн Санхүү, Төрийн сангийн хэлтэс нь Хэлтсийн дарга, Төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий нягтлан бодогч, Төсвийн мэргэжилтэн, Бүртгэлийн мэргэжилтэн, төлбөр тооцооны 2 мэргэжилтэн Орон нутаг дахь төсвийн төлөвлөлт, хэрэгжилт, тайлагналтыг хариуцан ажиллаж байна.

Төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтнийг аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэст харъяалуулан ажиллуулж байгаа нь Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан зааврыг зөрчиж байна.

А.2 Төрийн сангийн чиг үүргийг шинэчлэн сайжруулах шаардлагатай байна.

МУ-ын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь заалт, Засгийн газрын 2014 оны 326 дугаар тогтоолуудыг үндэслэн 2015 оны 1 сараас сумдад сумын Засаг даргын захирамжаар Санхүүгийн алба байгуулан ажиллуулсан байна.

Улиастай, Тосонцэнгэл сумдын санхүүгийн алба нь албаны дарга, төсөв төрийн сангийн мэргэжилтэн, сумын ЗДТГ-ын нягтлан бодогч, бусад сумын санхүүгийн алба нь албаны дарга, төсөв төрийн сангийн мэргэжилтэн, 2 нягтлан бодогчид санхүүгийн албандаа харъяалагдан төрийн сангийн үйл ажиллагааг зохион байгуулан ажиллаж байна.

“Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд ”-д хийсэн санхүүгийн аудитын тайлан

Сумдын нягтлан бодогчдоос нэг нь ЗДТГ, ИТХ, Эрүүл мэндийн төв, нөгөө нь ЕБС, хүүхдийн цэцэрлэг, соёлын төвийн нягтлангийн ажлыг хариуцан хийж, ЗДТГазарт байршин ажил үйлчилгээгээ явуулж байгаа нь эд хөрөнгөнд тавих хяналт сулрах, нэг нягтлан бодогчийн ажлын ачаалал ихсэх байдлыг үүсгэж байна.

Бодит байдал дээр санхүүгийн ажилтнуудын ажлын ачааллыг тэнцүүлэх зорилгоор Санхүүгийн албаны даргад ОНХС, СХС болон бусад сангуудын бүртгэл тайлагналыг хариуцуулан ажиллаж байна.

Сумдын санхүүгийн албаны дарга төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг гарган аймгийн төрийн санд хүргүүлэн ажиллаж байгаа бөгөөд түүндээ дүн шинжилгээ хийдэггүй, татварын орлогын давсан хэсгийг сумын ИТХ-аар шийдвэр гаргуулан зарцуулж байгаад хяналт тавьж ажилладаггүй дутагдлууд нийтлэг байна.

Иймд сумын санхүүгийн албаны даргын хариуцлагын талаарх заалтыг холбогдох хуульд тусган оруулах шаардлага байна гэж үзлээ.

А.3 Төрийн сангийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод зарим заалтуудыг оновчтой тусгаагүй байна.

Аймгийн санхүү, төрийн сангийн хэлтсийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг хянан үзэхэд тус аудиттай давхардан Сангийн яамны Төрийн сангийн газраас 2018 оны 10 сарын 14-21-ны өдрүүдэд хийгдсэн хяналтаар ажлын байрны тодорхойлолтонд тусгаагдаагүй заалтуудыг ажиллах явцдаа шинэчлэн батлуулж ажилласан байна.

Асгат, Идэр, Баянтэс, Алдархаан, Их-уул, Отгон, Улиастай, Завханмандал сумдын төрийн сангийн ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтод туссан үзүүлэлтүүдийг Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан заавартай тулгахад:

- Санхүүгийн албаны дарга нарын ажлын байрны тодорхойлолтонд дээрх тушаалаар батлагдсан зааврын 2.1.5, 2.1.7, 2.1.12, 2.1.20, 2.1.22, 2.1.25
- Төсөв, төрийн сангийн мэргэжилтний ажлын байрны тодорхойлтын 2.2.6, 2.2.8, 2.2.10
- Нягтлан бодогчийн ажлын байрны тодорхойлтын 2.3.3 2.3.5, 2.3.6 гэсэн заалтуудыг оновчтой тусгаагүй байгаад зөвлөмж хүргүүлэн ажиллаа.

Аудитын явцад төрийн сантай бусад хэлтсүүдээс ажлын чиглэлийн хувьд илүү харьцаатай байдаг хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтнүүдийн ажлын байрны тодорхойлолт, чиг үүргийн давхардлыг шалгахад давхацсан ажлын чиг үүрэг гараагүй болно.

А.4 Эдийн засгийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гарган биелэлтийг тооцон ажиллаж байна.

Завхан аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт Эдийн засгийн хөгжлийн чиглэлээр санхүү эдийн засагт төсвийн үр ашигтай, хэмнэлттэй, ил тод, шуурхай байдлыг хангуулахаар 3 зорилт тавин ажиллаж байна.

1. Далд эдийн засгийг илрүүлэх, татварын суурийг өргөжүүлэх замаар орон нутгийн төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.
2. Аймаг сумын эдийн засаг нийгмийг бодит байдалд тулгуурлан төсвийн төлөвлөлт, хувиарлалтыг оновчтой болгож эдийн засгийн чадавхийг нэмэгдүүлнэ.
3. Бүх шатанд төсвийн үр дүнтэй, хэмнэлттэй, хариуцлагатай байдлыг хангуулж хяналтын системийг сайжруулна.

Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлд Эдийн засгийн бодлогын хүрээнд төсвийн ил тод байдлыг хангаж, бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг сайжруулан, мэдээлэл судалгааны чанар болон хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэхээр 7 арга хэмжээ төлөвлөсөнөөс 1 арга хэмжээ 40 хувийн хэрэгжилттэй бусад арга хэмжээ бүрэн биелсэн байна.

Аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэс нь 2017 оны хэлтсийн төлөвлөгөөгөө 4 зорилт бүхий 32 арга хэмжээ төлөвлөснөөс 8 арга хэмжээ 70-90 хувийн хэрэгжилттэй бусад арга хэмжээ бүрэн биелсэн байна.

Завхан аймгийн Засаг дарга 2017 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн А/03 захирамжаар Сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, өдөр тутмын төлөвлөгөөт хяналтыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсан байна.

Аймгийн төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хууль эрх зүйн актын хэрэгжүүлэлт, үйл ажиллагаанд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төлбөр тооцооны хяналтыг сайжруулах ажлын хүрээнд төрийн сангийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийх удирдамж боловсруулан Аймгийн ЗДТГ-ын даргаар батлуулж дотоод хяналтыг 2017 оны 01 дүгээр сарын 01-ээс 12-р сарын 31 –ний хугацаанд хэрэгжүүлж тайланг Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Санхүү төрийн сангийн хэлтэс нь сумдын санхүүгийн албаны үйл ажиллагаанд тулгарч буй эрсдлийг бууруулах зорилгоор төрийн сангийн эрсдлийг бууруулах төлөвлөгөө гаргуулан биелэлтийг тооцуулан ажилласан байна.

“Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд ”-д хийсэн санхүүгийн аудитын тайлан

Тус хяналтыг хүснэгтээр харуулбал.

№	Сумдын нэр	Төрийн сангийн эрсдлийг бууруулах төлөвлөгөө боловсруулсан эсэх	Төрийн сангийн эрсдлийг бууруулах төлөвлөгөөний биелэлт гаргасан эсэх	ЗДТГ-ын Дотоод аудит үнэлсэн талаар	Төрийн Аудитаар шалгасан дүн
1	Алдархаан	Тийм	Тийм	Тийм	Тийм
2	Асгат	Тийм	Тийм	Тийм	Тийм
3	Баянхайрхан	Тийм	Тийм	Тийм	Тийм
4	Баянтэс	Тийм	Тийм	Тийм	Тийм
5	Дөрвөлжин	Тийм	үгүй	Биелэлт гаргаагүй	Биелэлт гаргаагүй
6	Завханмандал	Тийм	Тийм	Тийм	Тийм
7	Идэр	Тийм	Тийм	Тийм	Тийм
8	Их-Уул	Тийм	үгүй	Биелэлт гаргаагүй	Биелэлт гаргаагүй
9	Нөмрөг	Тийм	үгүй	Биелэлт гаргаагүй	Биелэлт гаргаагүй
10	Отгон	Тийм	Тийм	Тийм	Тийм
11	Сантмаргаз	Тийм	Тийм	Тийм	Тийм
12	Сонгино	Тийм	Тийм	Тийм	Тийм
13	Тосонцэнгэл	Тийм	Тийм	Тийм	Тийм
14	Түдэвтэй	Тийм	үгүй	Биелэлт гаргаагүй	Биелэлт гаргаагүй
15	Тэлмэн	Тийм	үгүй	Биелэлт гаргаагүй	Биелэлт гаргаагүй
16	Тэс	Тийм	Тийм	Тийм	Тийм
17	Улиастай	Тийм	Тийм	Тийм	Тийм
18	Ургамал	Тийм	Тийм	Тийм	Тийм
19	Цагаанхайрхан	Тийм	Тийм	Тийм	Тийм
20	Цагаанчулуут	Тийм	үгүй	Биелэлт гаргаагүй	Биелэлт гаргаагүй
21	Цэцэн-Уул	Тийм	Тийм	Тийм	Тийм
22	Шилүүстэй	Тийм	Тийм	Тийм	Тийм
23	Эрдэнэхайрхан	Тийм	Тийм	Тийм	Тийм
24	Яруу	Тийм	Тийм	Тийм	Тийм
25	Аймгийн төрийн сан	Тийм	Тийм	Тийм	Тийм

Зорилт Б. Төсөвт байгууллагуудыг төрийн сангийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлснээр, төсвийг хянах бололцоо бүрдсэн байна.

Б.1 Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг сумдын төрийн сан бүрэн хэрэгжүүлэхгүй байна.

Аудитыг аймгийн болон 24 сумын төрийн сан, санхүүгийн албаны 2017 оны үйл ажиллагаатай холбоотой баримт материалд тулгуурлан гүйцэтгэж 11 сумдад томилолтоор ажиллан аймгийн төрийн санг түүвэрлэн үзлээ.

“Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд ”-д хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитаар шалгагдсан төсөвт байгууллагын батлагдсан төлбөрийн хүсэлтээр гүйлгээ гаргасан эсэхийг шалгахад дараах алдаа зөрчил илэрч байна.

- Их-уул, Асгат, Завханмандал, Алдархаан сумдын төсөвт байгууллагуудын төлбөрийн хүсэлтийн хяналтын хуудасны бөглөлт хангалтгүй байхад төрийн сангийн мэргэжилтэн гүйлгээг хийсэн.
- Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам” –ын 7.5, 7.12, 7.14, 8.4, 8.5 дахь заалтуудыг зөрчин шаардлага хангаагүй баримтаар гүйлгээ хийсэн дутагдлууд илэрлээ. Тухайлбал:

Асгат, Яруу, Тэс, Алдархаан, Баянтэс, Дөрвөлжин, Отгон, Баянхайрхан сумдын төрийн сангийн нэгжүүд байгууллагын дарга, нягтлан бодогчийн гарын үсэг тамга тэмдэггүй баримтаар гүйлгээ хийсэн,

Дөрвөлжин сумын цэцэрлэг байгууллагын 2-р гарын үсгийн баталгааг зөрчсөн байхад гүйлгээ хийсэн,

Асгат, Цагаанчулуут, Тэс, Яруу, Түдэвтэй сумдын төрийн сангийн мэргэжилтэн хийсэн гүйлгээг хянан баталгаажуулаагүй,

Тэс, Асгат, Тэлмэн Цагаанчулуут, Яруу, Цагаанхайрхан, Цэцэн-уул сумдын төрийн сангийн мэргэжилтэн гараар зассан баримтаар гүйлгээ хийсэн,

Их-уул, Отгон сумдын төрийн сан данс андуурч гаргасан зарлагын гүйлгээнд мемориалын баримт үйлдээгүй,

Идэр сумын төрийн сан тамга, 2-р гарын үсэггүй байхад гүйлгээ хийсэн зэрэг зөрчил илэрсэнд баримтын бүрдлийг ханган хариу ирүүлэх, алдааг дахин давтахгүй байх зөвлөмж өгч ажиллаа.

Аудитаар дээрх алдаатай холбоотой нийт 1,298.6 сая төгрөгийн зөрчил илэрлээ.

Алдаа зөрчлийг графикаар харуулбал.



“Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд ”-д хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аймаг, сумын Төрийн сан нь төрийн сангийн үйл ажиллагааны журмын дагуу төсвийн байгууллагуудын бүртгэлийн дансаарх орлого, зарлагын гүйлгээг хянаж батлагдсан төсвийн хуваарийн дагуу, төлбөр тооцоог гүйцэтгэж байна.

Завхан аймгийн төсвийн ерөнхий нягтлан бодогч, сумдын санхүүгийн албаны дарга нь 2017 онд төсвийн санхүүжилтийн эрхийг болон батлагдсан төлөвлөгөөний дагуу сар бүрийн зарцуулах эрхийг орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудад олгож байна.

Аудитын явцад гарын үсгийн баталгааг маягтын дагуу гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчаар баталгаажуулж, нотариатаар батлуулаагүй, зарлагын гүйлгээг хийх эрх бүхий 1,2-р гарын үсгийг зураагүй, байгууллагын тамга дарагдаагүй, төрийн сангийн мемориалын баримтанд тэмдэглэгээ хийдэггүй гэсэн нийтлэг зөрчил зарим сумдын төрийн сангуудад байна.

Тайлант онд аймаг, сумдын төрийн санд Сангийн сайдын 2013 оны 73 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн санхүүжилтийн болон зарцуулалтын эрхийн тухай журам”-аар зардлын бүлэг хооронд шилжүүлэх гүйлгээ хийгдээгүй байна.

Аймгийн төсөвт байгууллагууд нь тухайн жилийн батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн зарлагын сар, улирлын мэдээ, ОНХСангийн болон бусад тусгай зориулалттай сангуудын бүрдүүлэлт, зарцуулалт болон орон нутгийн төсвийн орлогын мэдээ, аудитын дүгнэлт зэргийг төсөв, санхүүгийн ил тод байдлын самбар, шилэн дансанд байрлуулан иргэд, олон нийтэд тогтмол мэдээлж байна.

Аймгийн төсвийн зарцуулалтыг графикаар харуулвал.



Сумдын Төрийн сангийн төлөөлөгч нь төсөвт байгууллагуудын төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 2-ны дотор, жилийн эцэст төсвийн гүйцэтгэлийн тайланг сумын төсөвт байгууллагуудаар нэгтгэн аймгийн СТСХэлтэст өгдөг байна.

Б.2 ЗГСУМС нь төрийн сангийн хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж байна

“Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд ”-д хийсэн санхүүгийн аудитын тайлан

Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд хийсэн ажил, гүйлгээ, тайлангийн мэдээллүүдийг Сангийн яамны сайт болон дотоод сүлжээгээр хэрэглэгчдэд хүргэж байна.

ЗГСУМС нь төрийн сангийн хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж байна.

ЗГСУМС нь боловсронгуй болсноор дараах давуу талуудтай болсон байна. Үүнд:

- шаардлагатай тоон үзүүлэлтүүдийг оруулан мэдээ тайланг цаг тухай бүрт нь харж байхаар тохируулсан,
- төсвийн орлого, зарлагын хяналт сайжирсан,
- тухайн системээс шаардлагатай мэдээллийг олон хэлбэрээр хүссэн үзүүлэлтээр татан ашиглах боломж бүрдсэн,
- цахим мэдээлэлд дүн шинжилгээ хийдэг болгож сайжруулсан гэх мэт.

Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд хийгдсэн төсвийн санхүүжилт, төлбөр тооцоог баталгаажсан тухай бүрд нь төрийн сангаар үйлчлүүлэгч төсвийн байгууллагын нягтлан бодогчид өөрсдийн нэвтрэх эрхээр Сангийн яамны mof.gov.mn хаягаар хандан бүртгэлийн дансныхаа хяналтын түвшин болон төсвийн хэлбэлзэл, орлогын дэлгэрэнгүй, зарлагын дэлгэрэнгүй, ня-бо журнал, төсвийн тайлан /бүлэгтэй/, дансны хяналт, дансны хуулгыг харах, хэвлэх боломжтой байна.

Төсвийн зарцуулалтын эрхийн баталгааг нээхдээ эдийн засгийн ангилал тус бүрээр оруулсан нь хяналт тавихад хялбар болсон байна.

Аудитын явцад төрийн сангийн ажилтнуудаас авсан санал асуулгыг графикаар харуулбал:




“Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд ”-д хийсэн санхүүгийн аудитын тайлан

ЗГСУМС нь шаардлагатай үйл ажиллагааны хүрээг хамарч чадсан уу?



ЗГСУМС-д өгөгдөл оруулах, тайлан, мэдээ гаргах явцад саатал бэрхшээл хэр гардаг вэ?



Төрийн сангийн нэгдсэн тогтолцоонд ашиглагдаж байгаа Free balance программын нэгдсэн удирдлага нь Сангийн яамны төрийн сангийн газарт байршиж байна.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс, сумын санхүүгийн албаны хувьд системд нэвтэрч журнал ваучер, ТБ1, ТБ1 шилжүүлэг, төсөв, төсөв хоорондын шилжүүлгийг нэмэх, засах, устгах, харах, хадгалах, ТБ2, зардлын ваучер болон системээс гарах тайлангууд харах, гүйлгээ баталгаажуулах, бэлтгэн нийлүүлэгч нэмэх зэрэг үүргүүдийг тус тус гүйцэтгэж байна.

Аймгийн төрийн сангийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн, сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтнүүдийн ашиглаж буй мэдээллүүд нь төв төрийн сантай цахимаар холбогдсон тул программд өөрчлөлт хийх, нэмэлт мэдээлэл оруулах эсэх нь Сангийн яамны төрийн сангийн газраас хамааралтай байна.

Гүйлгээ саатах, алдаа өгөх зэрэг системийн доголдол гарсан тохиолдолд аймгийн төлбөр тооцоо хариуцсан болон сумын төсөв, төрийн сангийн мэргэжилтнүүд ямар ч үйлчилгээ үзүүлэх боломжгүй Сангийн яамны мэргэжилтэнд хандаж шийдвэрлүүлж байна.

Асгат сумын төрийн сангийн тоног төхөөрөмж 2018 оны 06 сард эвдэрч, Сангийн яам болон тоног төхөөрөмжийн засварын компани руу удаа дараа хандахад ашиглах боломжгүй, шинээр ав гэсэн хариу өгсөн, тоног төхөөрөмжийн асуудал одоо болтол шийдвэрлэгдээгүй байна.

“Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд ”-д хийсэн санхүүгийн аудитын тайлан

Асгат сум нь зэргэлдээх Баянтэс, Баянхайрхан сумуудад очиж тухайн сарынхаа гүйлгээг хийж байгаа, шинээр авах тоног төхөөрөмж төсөвт тусгагдаагүй учраас авах боломжгүй байна.

Сумдын төрийн санд ашиглагдаж байгаа Mercury-800, tainet төхөөрөмжүүдэд саатал, доголдол гараад шалгах тохиолдолд тухайн сумын ЗДТГ-аас Монголын цахилгаан холбоо руу зөвшөөрөл авах албан тоот явуулж хариу ирэхээр төхөөрөмжөө шалгадаг хүндрэлүүд байна.

Сангийн сайдын 2014 оны 95 тоот тушаалаар “Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн системд мөрдөх” журмыг шинэчлэн баталж, 2015 оны 129 тоот тушаалаар нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Уг журмын 1 дүгээр хавсралтаар түр хугацаагаар хэрэглэгчийн нэр, нууц үг шилжүүлэх, 2 дугаар хавсралтаар ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан хэрэглэгчийн нэр, нууц үг шилжүүлэх хүснэгтүүдийг тухай бүр хийж хэвшжээ.

Санал асуулгыг графикаар харуулбал



:

Б.3. Сумдын төрийн сангийн нэгжүүд зөвлөмжийн хариу ирүүлээгүй, илрүүлсэн алдаа зөрчлүүд нь дахин давтагдсаар байна.

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсээс Улиастай, Отгон, Шилүүстэй, Цагаанчулуут, Тосонцэнгэл, Их Уул, Нөмрөг, Тэс, Сонгино сумдын 2016 оны 1-12 сар, 2017 оны эхний 4 саруудын төрийн сангийн үйл ажиллагааг хамруулан дотоод хяналт хийгдэж 16 заалт бүхий зөвлөмж өгөгдсөн ч зөвлөмж ирүүлэх хугацааг зааж өгөөгүй, зөвлөмжийн хариуг сум тус бүрээс албан тоот болон нотлох баримтын хамт аваагүй, алдаа зөрчлүүд нь дахин давтагдсаар байгаа нь дотоод хяналтын үр дүн хангалтгүй байгааг харуулж байна.

“Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд ”-д хийсэн санхүүгийн аудитын тайлан

Давтагдан гарч буй алдаануудад:

- Дөрвөлжин сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, Отгон сумын Эрүүл мэндийн төвийн эрхлэгч их эмч нарын гарын үсгийн баталгаан дахь гарын үсэг, төлбөрийн хүсэлт дэх гарын үсгүүд зөрүүтэй,
- Отгон, Шилүүстэй сумын нийгмийн даатгалын байцаагчид 1-р гарын үсэг зурж нийгмийн даатгалын сангуудын гүйлгээг хийсэн,
- Тэлмэн сумын төрийн сан нийгмийн даатгалын гүйлгээг 1-р гарын үсэггүй байхад гүйлгээ хийсэн,
- Сонгино сумын нийгмийн даатгалын сангуудын гүйлгээнд 2-р гарын үсгийг ЗДТГ-ын санхүүгийн албаны дарга зурсан,
- Төрийн сангийн үйл ажиллагааны журмаар хориглосон орлого бууруулах төлбөр тооцоо болон зарлагын гүйлгээ гаргасан эсэхийг мемориалын баримтаас хянан үзэхэд гүйлгээ нэр данс зөрүүгээр орж ирсэн байгаа ба нэр данс зөрүүгээр гаргасан боловч орлогын хуулга хавсаргаагүй зарлагын гүйлгээнүүд байна,
- Төлбөрийн хүсэлтийн ТТ-1, ТТ-2 маягтын бүрдлийг хянахад мөнгөн дүн, ангилал, огноо засвартай баримтаар гүйлгээ хийсэн
- Төлбөрийн хүсэлт дээр гүйлгээ хийж буй төсөвт байгууллагын 1, 2-р гарын үсэггүй, байгууллагын тамга, тэмдэг дараагүй байхад гүйлгээ хийсэн,
- Төсөв, төрийн сангийн мэргэжилтний гүйлгээ хийсэн огноо, тэмдэг, гарын үсэггүй байхад гүйлгээ хийгдсэн,
- Төсөв, төрийн сангийн мэргэжилтэн төлбөрийн хүсэлтийн төрийн сангийн тэмдэглэгээн дээр тулгалт хийсэн тэмдэглэгээ хийгээгүй,
- Төсөвт байгууллагын төлбөр тооцоог журамд заасны дагуу ажлын 3 хоногт багтаан шивж баталгаажуулаагүй,
- Төрийн сангийн гүйлгээг алдаатай шивж банк хооронд баталгаажиж гарахаас өмнө залруулж ажилласан ч журамд заасны дагуу мемориалын баримт үйлдэн мемориалд хавсаргаагүй байна,
- Төсвийн байгууллагын төлбөрийг гүйцэтгэж ажиллаж байгаа байдлыг хянан үзэхэд батлагдсан төсөв эдийн засгийн ангиллаас гаргаагүй, үндэслэх баримт хяналтын хуудас зөрүүтэй,
- Хөрөнгө зарцуулсан захирамж, тушаал, шийдвэрт зардлын эдийн засгийн ангиллыг зааж өгөөгүй, хавсралтаар хөрөнгө зарцуулах төсөв батлаагүй,
- Төсвийн байгууллагын нягтлан бодогч нар нягтлан бодох бүртгэлийн программдаа төсвийн хуваарийг шивээгүйгээс төсвийн гүйцэтгэлийн мэдээг программаас гаргаагүй зэрэг алдаанууд байна.

Б.3.2 Төсвийн хэрэгжилт, мөнгө хөрөнгийн удирдлагад тавих дотоод хяналт шаардлагын хэмжээнд байна.

Аймгийн 24 сумын төрийн сангийн нэгж Сангийн сайдын 2014 оны 65 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналтын

“Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд ”-д хийсэн санхүүгийн аудитын тайлан

журам”-ын 1, 2 дугаар хавсралтын дагуу төрийн сангийн эрсдэл бууруулах төлөвлөгөө, төлөвлөгөөний биелэлтийг бүрэн ирүүлэн ажиллажээ.

Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс 2017 онд төрийн сангийн эрсдлийн үнэлгээг бүх сумдыг хамруулан цахим хэлбэрээр санал асуулга авч гүйцэтгэсэн байна.

Санал асуулгаар өмнөх оноос Тосонцэнгэл, Тэс, Нөмрөг, Их Уул сумдын төрийн сангийн нэгжийн эрсдэл өссөн, Отгон сумын эрсдэл хэвийн хэмжээнд, Алдархаан, Асгат, Завханмандал, Түдэвтэй, Цагаанчулуут, Шилүүстэй, Эрдэнэхайрхан, Яруу сумдын болон аймгийн төвийн төрийн сангийн нэгжийн эрсдэл буурсан байна.

Эрсдэл буурсан шалтгааныг судлан дүгнэхэд санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн ЗГСУМС-ийг ажиллуулахад дадлагажиж, удирдлагыг мэдээллээр хангах нь сайжирсан зэрэгтэй холбоотой байна гэж үзлээ.

Дүгнэлт.

Сангийн сайдын 2015 оны 90 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар-ын дагуу ажлын байрны тодорхойлолтыг оновчтой боловсруулаагүй,

Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналт шалгалтаар илэрсэн алдаа зөрчил буурахгүй дахин давтагдсаар байгаад цаашид таслан зогсоох шаардлагатай байна.

Сумын төрийн сангийн төлөөлөгч ажлын ачааллаас шалтгаалан үндсэн чиг үүрэг, хяналтыг бүрэн хэрэгжүүлэх боломжгүй байна.

Сумын төрийн сангийн төлөөлөгч, бүртгэлийн дансны гүйлгээ шивдэг нягтлан бодогч эзгүй амралттай, өвчтэй байх хугацаанд ажил үүргийг шилжүүлэн гүйцэтгэхэд түүнийг зохицуулах эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

ДАРГА БӨГӨӨД

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

“Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд ”-д хийсэн санхүүгийн аудитын тайлан

Зөвлөмж

Аймгийн ЗДТГ-ын дарга Л.Лхамсүрэн-д

“Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд ” хийсэн санхүүгийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Аймгийн төрийн сангийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтний ажлын байрны тодорхойлолтыг журмын дагуу шинэчлэн батлах, ажлын байрны орон тооны дагуу аймгийн санхүү төрийн сангийн хэлтэст харъяалуулах

Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Ж.Хүрэлбаатар-т

1. Төрийн сангийн үйл ажиллагааны дотоод хяналт шалгалтыг сайжруулах, төсөв төрийн сангийн мэргэжилтнүүдэд энэ онд багтаан тус аудитаар илэрсэн алдаа зөрчилд тулгуурлан мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч тайланг ирүүлэх,
2. Төрийн сангийн үйл ажиллагааны журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй Асгат, Яруу, Тэс сумдын төрийн сангийн нэгжүүдийн мемориалын баримтуудын бүрдлийг хангуулах,
3. Төсөвт байгууллагуудын Төрийн санд байгаа ашиглагдахгүй дансдуудыг хаалгах, Тухайлбал сонгуулийн данс гэх мэт

Тус аудитаас өгөгдсөн дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2019 оны 02-р сарын 25-ны дотор албан тоотоор ирүүлэх.

ДАРГА БӨГӨӨД

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

“Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд ”-д хийсэн санхүүгийн аудитын тайлан

Сумдын санхүүгийн албаны дарга нарт

“Төрийн сангийн тогтолцоо, үйл ажиллагааны үр дүнд ” хийсэн санхүүгийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Сангийн сайдын 2015 оны 90 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн санхүү, төрийн сангийн ажилтны ажил үүргийн жишиг заавар”-ын дагуу санхүүгийн албаны ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулан мөрдөж ажиллах
2. “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг бүрэн хэрэгжүүлж, аудитаар илэрсэн хавсралт судалгаанд тусгагдсан ТТ1, ТТ2 баримтуудын бүрдлийг ханган, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг дахин давтахгүй байх, мемориалын баримтуудыг стандартын дагуу архивлах
3. Сангийн сайдын 2016 оны 431 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн сангийн төлбөр тооцоо гүйцэтгэхэд үндэслэх баримт бичгийн жишиг заавар”-ыг мөрдөж ажиллах
4. Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын дагуу төлбөр тооцоо гүйцэтгэж байгаа төлбөрийн хүсэлтийн хяналтын хуудсыг анхан шатны баримттай тулган баталгаажуулж хэвших
5. Нэр данс зөрүүгээр буцаж орж ирсэн төлбөр тооцоог гүйцэтгэхдээ орлогын хуулга хавсаргаж байх

Тус аудитаас өгөгдсөн дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн, биелэлтийг 2019 оны 02-р сарын 25-ны дотор албан тоотоор ирүүлэх.

ДАРГА БӨГӨӨД

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР